

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №1-р баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2023 оны 3 дүгээр сарын 18-ны өдрийн  
02 тоот тогтоолын Хавсралт №1



## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа.

### Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Компани 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Шинэ их Тэрбум Аудит ХХК-ийг хөндлөнгийн аудитын компаниар сонгон ажилласан.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

|  |                  |
|--|------------------|
| Цалин  | 183.6 сая төгрөг |
| Аудит, мэргэжлийн үйлчилгээ                  | 3.1 сая төгрөг   |
| Түрээс                                       | 18.8 сая төгрөг  |
| Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал | 23.3 сая төгрөг  |
| Маркетинг сурталчилгаа                       | 1.2 сая төгрөг   |
| Зохицуулалт үйлчилгээний хураамж             | 166.8 сая төгрөг |
| Зээл барагдуулахтай холбоотой зардал         | 0.9 сая төгрөг   |
| Албан томилолт                               | 26.7 сая төгрөг  |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг                | 228.0 сая төгрөг |

**Авлага, өглөгийн талаар:**

Тайлант хугацаанд Итгэлцлийн үйлчилгээний 3,4 тэрбум төгрөгийн өглөгтэй, Итгэлцлийн хүүний өглөг, татварын өглөг нийлээд 301,4 сая төгрөгийн өглөгтэй байсан.

**Үндсэн хөрөнгийн талаар:**

2022 оны эцсийн байдлаар 486,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болно.

**Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:**

Компанийн 2022 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

**ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо**

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нөхөн сонгосугай.

А. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. Чулуун овогтой Чинзориг
2. Лхагваа овогтой Очирмаа
3. Цэдэндорж овогтой Билэг-Өрнөх
4. Пунцагноров овогтой Чинзориг
5. Чулуун овогтой Бадмаараг
6. Чинзориг овогтой Тэмүдэр

Б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Бямбажав овогтой Энх-Амгалан
2. Чоймаа овогтой Лодойравсал
3. Алтангэрэл овогтой Даваазориг

3. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## Хаалттай хүрээнд бонд гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 42 дугаар зүйлийн 42.1, 62 дугаар зүйлийн 62.2.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд богино болон дунд хугацаанд гаргах бондыг тухайн үеийн цаг үетэй уялдуулан 12,000,000,000 төгрөгийн 2 үе шаттай гаргах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дах заалт, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 62 дугаар зүйлийн 62.2.1 дэх заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд богино болон дунд хугацаанд гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тухайн үеийн цаг үетэй уялдуулан 10,000,000,000 төгрөгийн хэмжээтэй гаргах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2023 оны 3 дүгээр сарын 18-ны өдрийн  
06 тоот тогтоолын Хавсралт №1



Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

| №        | Зардлын төрөл                    | Тоо | Нэгжийн зардал | Нийт зардал |
|----------|----------------------------------|-----|----------------|-------------|
| 1        | Цалин /дарга/                    | 1   | 710,000        | 8,520,000   |
| 2        | Цалин /гишүүд/                   | 8   | 550,000        | 52,800,000  |
| 3        | Цалин/ нарийн бичгийн дарга/     | 1   | 550,000        | 6,600,000   |
| 4        | ГУЗ-ийн ээлжит хурлын зардал     | 4   | 350,000        | 1,400,000   |
| 5        | ГУЗ-ийн ээлжит бус хурлын зардал | 6   | 350,000        | 2,100,000   |
| 6        | ГУЗ-ийн хурал уулзалтын зардал   |     |                | 25,000,000  |
| 4        | ГУЗ-н бичиг хэрэг                |     |                | 500,000     |
| 5        | ГУЗ-ын томилолт                  |     |                | 20,000,000  |
| Нийт дүн |                                  |     |                | 116,920,000 |